

**МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХИ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

НЭГ.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ:

**Нэг.ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ ЗАРДЛЫГ
БУУРУУЛАХ САНАЛ**

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад туссан гадаад зээлийн ашиглалт, санхүүжих зардлыг **117.0 тэрбум** төгрөгөөр бууруулах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Тогтохсүрэн, Б.Жавхлан,
Н.Амарзаяа, Ж.Батзандан, Б.Баттөмөр, Л.Болд, З.Нарантуяа,
Л.Оюун-Эрдэнэ, Н.Оюундарь, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж,
Г.Тэмүүлэн, Б.Ундармаа, Б.Чойжилсүрэн, Л.Энхболд, цаашид
“Ажлын хэсэг” гэх.**

Хоёр.УРСГАЛ ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛ

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дахь "Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр" дэх зээлийн хүүгийн татаас арга хэмжээнд төлөвлөсөн төсвийг **1,836.6 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд Үндэсний аудитын газрын хийсэн дүгнэлтэд дурдсаныг үндэслэн их, дээд сургуулийн тогтмол зардалд төсвөөс олгож байгаа санхүүжилтийг **4.6 тэрбум** төгрөгөөр бууруулах

Санал гаргасан: Ажлын хэсэг

Гурав.УРСГАЛ ЗАРДАЛ НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

1.Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг **62.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлж, эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцож Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгах

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Концессоор хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хийх аудитын зардал болох **145.1 сая** төгрөгийг Ерөнхий аудиторын төсвийн багцад нэмж тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Малын генетик нөөцийн тухай, Малын эрүүл мэндийн тухай хууль хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулж **1.0 тэрбум** төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын урсгал зардалд нэмж тусгах

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологийн судалгааны ажилд зориулж **500.0** сая төгрөгийг Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын урсгал зардалд нэмж тусгах

Санал гаргасан: Ажлын хэсэг

5.Биеийн тамир, спортын газрын урсгал зардлыг **1.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

6.Соёл, урлагийг дэмжих сангийн урсгал зардлыг **1.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

7.Завхан аймгийн Онцгой байдлын газрын Улиастай сумын галын депогийн байр, гал түймэр унтраах, аврах 57 дугаар ангийн гэрэл, цахилгаан, цэвэр, бохир ус, түлш, халаалтын тогтмол зардлыг **130.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэн, Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

8.Төсөв, эдийн засгийн чиглэлийн хууль тогтоомжуудыг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах, тэдгээрийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, сурталчлах, дүн шинжилгээ, судалгаа хийх, сургалт, семинар зохион байгуулахад зориулж, **400.0** сая төгрөгөөр Улсын Их Хурлын урсгал зардлыг нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

9.Хүүхэд хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах урсгал зардлыг **1.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцад тусгах

Санал гаргасан: Ажлын хэсэг

10.Хүний эрхийн үндэсний комиссын урсгал зардлыг **300.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Дөрөв. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛ

1.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.2.1.17-д тусгагдсан "Соёлын төвийн барилга, 250 суудал, /Өвөрхангай, Тарагт сум/ гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг "1,500.0 сая" гэснийг **"500.0 сая"** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.1.13-д тусгагдсан "Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх, хатуу хучилттай авто зам 4.4 км /Баянхонгор, Өлзийт сум/" гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг "3,400.0 сая" гэснийг **"83.1 сая"** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Өмнөх онуудад олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг нь үндэслэн саналын томъёоллын хавсралт 1-т тусгагдсан 6 төсөл, арга хэмжээний 2018 онд санхүүжих дүнг **927.4 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XYI.1.22-д тусгагдсан "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга, Говь-Сүмбэр, Дорноговь, Боржигон-эко төсөл" гэсэн төсөл арга хэмжээний 2018 онд санхүүжих дүн "2300.0 сая" гэснийг **"1,100.0 сая"** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Тав. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

1.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.2.2-д тусгагдсан "Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалт /улсын хэмжээнд/" гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2018 онд санхүүжих дүнг тус тус **4.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.1.29-д тусгагдсан "Чоно харайхын гүүр барих /Завхан, Дөрвөлжин сум/, хэрэгжих хугацаа 2018-2018, төсөвт өртөг "20.0 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "20.0 сая" төгрөг гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2018 онд санхүүжих дүнг тус тус **50.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад саналын томъёоллын хавсралт 2-д тусгагдсан **49,079.2 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **24,802.0 сая** төгрөгийн 2018 онд санхүүжих дүнтэй **47** төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын саналын томъёоллын хавсралт 3-т тусгагдсан төсөл, арга хэмжээний 2018 онд санхүүжих дүнг **24,500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэн, **49** төсөл, арга хэмжээний хэрэгжиж дуусах хугацааг хавсралтад дурдсанаар өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

5.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.1.5-д тусгагдсан "Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар/", хэрэгжих хугацаа 2015-2018, төсөвт өртөг "2,300.0 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "1,500.0 сая" төгрөг гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2018 онд санхүүжих дүнг тус тус **"3,500.0 сая"** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

6.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын II.3.1-д тусгагдсан "Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2018-2018, төсөвт өртөг "800.0 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "800.0 сая" төгрөг" гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2018 онд санхүүжих дүнг тус тус **1,113.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

Зургаа.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2018 ОНД САНХҮҮЖИХ ДҮНД НӨЛӨӨЛӨХГҮЙ ЗАРЧМЫН САНАЛ

1.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.3.1.10-д тусгагдсан "Спорт цогцолборын барилга, 450 суудал /Ховд, Булган сум/" гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг "4750.0 сая" гэснийг "3500.0 сая" гэж, 2018 онд санхүүжих дүн "1250.0 сая" гэснийг "750.0 сая" гэж тус тус бууруулан, төсөлд "Сумын төвийн 10 кВт болон 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах шугам сүлжээний шинэчлэл, өргөтгөл, 10/0.4 кВт-ын дэд станцын өргөтгөл, Ховд, Булган, хэрэгжих хугацаа 2018-2019, төсөвт өртөг "1,990.1 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "500.0 сая" төгрөг" гэсэн төсөл арга хэмжээг нэмж тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын X.3.1.1-д тусгагдсан "Усан спорт цогцолбор, /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Найрамдал зуслан/ гэсэн төсөл арга хэмжээний 2018 онд санхүүжих дүн "2300.0 сая" гэснийг "1300.0 сая" гэж бууруулан, төсөлд "Хүний хөгжлийн төвийн барилга, Өвөрхангай, Арвайхээр сум, хэрэгжих хугацаа 2018-2019, төсөвт өртөг "2,000.0 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "1000.0 сая" төгрөг" гэсэн төсөл арга хэмжээг нэмж тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XII.1.40-д тусгагдсан "Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11-р хороо/" гэсэн төсөл арга хэмжээний байршилд 16 дугаар хороо гэж нэмж, энэ төсөл арга хэмжээг 2 төсөл, арга хэмжээ болгон салгаж, төсөвт өртөг болон санхүүжих дүнг нь тус бүрт нь "70.0 сая" төгрөг болгон өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1-д тусгагдсан "Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ гэсэн төсөл арга хэмжээний 2018 онд санхүүжих дүнг "2,300.0 сая" төгрөгөөр, ХҮIII.1.13-д тусгагдсан "Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах" төслийн монголын талын хөрөнгө гэсэн төсөл арга хэмжээний 2018 санхүүжих дүнг "500.0 сая" төгрөгөөр, ХҮIII.1.16-д тусгагдсан "Халдварт, сүрьеэгийн барилга, 30 ор /Булган, Булган сум/" гэсэн төсөл арга хэмжээний 2018 санхүүжих дүнг "500.0 сая" төгрөгөөр буюу нийт "3,300.0 сая" төгрөгөөр бууруулж, энэ бууруулсан дүнгээр саналын томъёоллын хавсралт 4-д тусгагдсан 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөлд нэмж тусгах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

5.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.1.201-д тусгагдсан "Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2018-2019, төсөвт өртөг "1,000.0 сая" төгрөг, 2018 онд санхүүжих дүн "500.0 сая" төгрөг гэсэн төсөл арга хэмжээний байршилд "22 дугаар хороо" гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

6.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.1.182-д тусгагдсан "Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2018-2019, төсөвт өртөг "3500,0 сая төгрөг", 2018 онд санхүүжих дүн "2,500.0 сая" төгрөг гэсэн төсөл арга хэмжээний байршилд "10 дугаар хороо" гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

7.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.2.2, XIII.1.3.1, XIII.1.3.2-д тусгагдсан тусгай сургуулийн дугаар "86" гэснийг "186" гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

8.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.1.37-д тусгагдсан "Гашууны голын төмөр бетон гүүр, 72.0 у/м /Увс, Улаангом/" гэсэн төсөл арга хэмжээг "... гүүрийн их засвар" болгон Зам тээврийн сайдын багц дотроо хөрөнгө оруулалтаас их засварт шилжүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

9.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XYII.1.1.14-д тусгагдсан "Эрчим хүчний дахин дамжуулах сүлжээ /Увс, Давст сум/" гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг

болон 2018 онд санхүүжих дүнг хэвээр үлдээж, Ерөнхий сайдын багцын хөрөнгө оруулалтын багц руу “Алслагдсан сумын үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ /Увс, Давст сум/ гэсэн нэртэйгээр шилжүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

10.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIY.1.2.13-д тусгагдсан “Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий, Дадал сум/” гэсэн төсөл, арга хэмжээний “Дадал” гэсний дараа “, Баян-Адарга” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

11.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.2.17-д тусгагдсан “Сургуулийн спорт заалын барилгын их засвар /Ховд, Чандмань сум/, хэрэгжих хугацаа 2018-2018, төсөвт өртөг “290.0 сая” төгрөг, 2018 онд санхүүжих дүн “290.0 сая” төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг “Прокурорын газрын барилга /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2018-2019, төсөвт өртөг “1,400.0 сая” төгрөг, 2018 онд санхүүжих дүн “290.0 сая” төгрөг” гэж өөрчлөн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын хөрөнгө оруулалтаас Ерөнхий прокурорын төсвийн багцын хөрөнгө оруулалт руу шилжүүлэх

Санал гаргасан: Ажлын хэсэг

12.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XII.1.35-д тусгагдсан “Орон сууцны хорооллын дулааны шугам сүлжээ /Говь-Алтай, Есөнбулаг сум, Солонго хороолол/ гэсэн төсөл арга хэмжээний “шугам сүлжээ” гэснийг “эх үүсвэр” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

13.Хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIII.1.1.133-д тусгагдсан “Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 280 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар цэцэрлэг/ гэсэн төсөл, арга хэмжээний байршлыг “Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

14./Нэгдсэн хуралдаанаар “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдвал хураалгана/ Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслүүдийг хэлэлцэх явцад Хүүхэд харах үйлчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хэвээр үлдээхээр зарчмын зөрүүтэй санал гарч дэмжигдсэн тул энэ санал Улсын Их Хурлаар дэмжигдсэн тохиолдолд Хүүхэд харах үйлчилгээний зардал 6,516.8 сая төгрөгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын багцад шилжүүлж тусгах

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар

Долоо. ЗАРЧМЫН БУСАД САНАЛ

1.Зардал нэмэгдэж, хасагдсантай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардлын дүнд холбогдох өөрчлөлтийг хийх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Хуулийн төсөлд зүйл, заалт нэмэгдэх, өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хасагдсан, нэмэгдсэнтэй холбогдуулан хууль болон хөрөнгө оруулалтын хавсралт дахь зүйл, заалт, арга хэмжээнүүдийн дугаарт өөрчлөлт оруулах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн 4 дэх заалтын дугаарыг "19.2.4" гэж, 25 дугаар зүйлийн "25.6", "25.6.1" гэсэн дугаарыг "25.5, 25.5.1" гэж өөрчлөх

Санал гаргасан: Ажлын хэсэг

**Найм.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС БОЛОН БУСАД
БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДЭМЖСЭН САНАЛ**

1.Төслийн нэгдүгээр хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад багтах 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт "Инноваци, өндөр технологийг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 2018 оны зорилтот түвшин 15" гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

2.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад багтах 13 дугаар зүйлийн XIII.1.1.166 дахь дэд заалтыг "Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/, эхлэх хугацаа 2018 он, дуусах хугацаа 2019, төсөвт өртөг 1,200.0 сая төгрөг, 2018 онд санхүүжих дүн 650.0 сая төгрөг" гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

3.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад багтах 13 дугаар зүйлийн 13.1.1.184 дэх дэд заалтын "Цэцэрлэгийн барилга, 250 ор" /Баян-Өлгий, Өлгий сум/ гэснийг "Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга" /Баян-Өлгий, Өлгий сум/ гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

4.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад багтах 13 дугаар зүйлийн 13.1.1.207 дахь дэд заалтын "13 дугаар хороо" гэснийг "16 дугаар хороо" гэж, мөн зүйлийн 13.1.1.81 дэх дэд заалтын "16 дугаар хороо" гэснийг "13 дугаар хороо" гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Гарамжав
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

5.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад багтах 13 дугаар зүйлийн XIII.1.1.1 дэх дэд заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээг "Япон улсын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Улаанбаатар хотын бүрэн дунд боловсролын сургуулийн барилгыг сайжруулах төслийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/", хэрэгжих хугацаа 2018-2020, төсөвт өртөг "3,000.0 сая" төгрөг, 2018 оны санхүүжих дүн "1,500.0 сая" төгрөг" гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

6.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багц дахь аялал жуулчлал хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,360.0 сая төгрөг болгох.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг
/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
дэмжээгүй/**

7.Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдын багцын аялал жуулчлал хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцын ойжуулалтын арга хэмжээний зардал болох 10,328.0 сая төгрөгийг 2.0 тэрбум төгрөгөөр бууруулж төсвийг тэнцвэржүүлэх

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар

8.Хүүхдийн байгууллага, хүүхэд хамгааллын зардалд "Хүүхдийн эрхийн тухай хууль", "Хүүхэд хамгааллын тухай хууль", "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-3.4.7 дэх заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлуудад 1,054.4 сая төгрөгийг тусгасан байгааг 3,945.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,000.0 сая төгрөг болгох

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Д.Оюунхорол, Н.Оюундарь, Д.Цогтбаатар,
Б.Саранчимэг, Ц.Цогзолмаа, Г.Мөнхцэцэг,
З.Нарантуяа**

ХОЁР.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖЭЭГҮЙ САНАЛ:

1. Гадаад харилцааны яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө” буюу өргөтгөлийн байранд агааржуулагч суурилуулахад шаардагдах 298.6 сая төгрөгийг Гадаад харилцааны сайдын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

2. Гадаад харилцааны сайдын хөрөнгө оруулалтын зардал дахь Дипломат төлөөлөгчийн газрын их засварын ажлын зардлыг 3,839.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

3. Гадаад харилцааны сайдын хөрөнгө оруулалтын зардал дахь Дипломат төлөөлөгчийн газарт автомашин худалдан авахад шаардлагатай зардлыг 1,230.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

4. Баян-Өлгий аймгийн Сагсай суманд байрлах Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн 24 айлын орон сууц барихад шаардагдах 2,800.0 сая төгрөгийг Батлан хамгаалахын сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

5. Зэвсэгт хүчний нөөцийн материал хэрэгслийг байршуулах барилга, байгууламж барихад шаардагдах 7,527.6 сая төгрөгийг Батлан хамгаалахын сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

6. Цэргийн төв эмнэлгийн цалин хөлсний тооцооллын зөрүүг арилгахад шаардлагатай 2,300.0 сая төгрөгийг Батлан хамгаалахын сайдын багцын урсгал зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

7. Шадар сайдын төсвийн урсгал зардал дахь онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт болон тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн хангалтын төсвийг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

8. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.8-д заасан онцгой байдлын байгууллагын албан хаагч нь мэргэжлийн зэрэгтэй байхаар заасныг хэрэгжүүлэхэд шаардагдах 2,900.0 сая төгрөгийг Шадар сайдын төсвийн багцын урсгал зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Я.Санжмятав
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

9. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.9-т заасан онцгой байдлын байгууллагын албан хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиас доошгүй байна гэснийг хэрэгжүүлэхэд шаардагдах 2,800.0 сая төгрөгийг Шадар сайдын багцын урсгал зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Я.Санжмятав
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

10. ОХУ-ын академи болон Хууль сахиулахын их сургууль, Удирдлагын академид суралцдаг онцгой байдлын байгууллагын 35 албан хаагчийн цалин хөлс, эрүүл мэндийн даатгалыг төлөхөд шаардагдах 319.5 сая төгрөгийг Шадар сайдын төсвийн багцын урсгал зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Я.Санжмятав
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

11. Цацрагийн 3 дугаар агуулахын зураг төслийн ажлыг гүйцэтгүүлэхэд шаардлагатай 154.0 сая төгрөгийг Монгол Улсын Ерөнхий сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

12.Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гадаргууны бохирдол хэмжих багажид баталгаажуулалт хийх эталон үүсгүүр Рn-239 хавтгай эталон үүсгүүр, Сl-36 хавтгай эталон үүсгүүр худалдан авахад шаардагдах 23.0 сая төгрөгийг Монгол Улсын Ерөнхий сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн/

13. Дайчилгааны хээрийн сургууль явуулахад шаардагдах 362.0 сая төгрөгийг Батлан хамгаалахын сайдын багцын Зэвсэгт хүчний Жанжин штабын хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй/

14. Монгол Улсын Ерөнхий сайдын багцын Цөмийн энергийн комиссын урсгал зардлын гадаад томилолтын зардлыг 175.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг
/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй/**

15. "Малын чанар үржлийн ажил үйлчилгээнд шаардлагатай 3,800.0 сая төгрөгийг" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардалд нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Д.Мурат
/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн/**

16. Байгаль орчин, аялал жуучлалын сайдын багцад "Морин-Уул дахь цаг уурын доплерийн радарын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэгт зориулж 1,040.0 сая төгрөгийг" нэмэх.

**Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн
/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй/**

17. Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад "Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж төслийн санхүүжилтэд шаардагдах 300.0 сая төгрөг" гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн/**

18. Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцын XIII.1.1.5 дахь дэд заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжиж дуусах хугацаа "2018" гэснийг "2020" гэж, төсөвт өртөг "2,300.0 сая төгрөг" гэснийг "15,200.0 сая төгрөг" гэж, 2018 онд санхүүжих дүн "1,500.0 сая төгрөг" гэснийг "5,000.0 сая төгрөг" гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн/**

19. Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын спортын салбарын хөрөнгө оруулалтын багцад багтах 13 дугаар зүйлийн XIII.3.1.1 дэх дэд заалтын 2018 оны санхүүжих дүнг 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганболд
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо дэмжсэн/**

20. Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын соёлын салбарын их засварын багцад "Соёлын төв, 100 суудал, /Дорноговь, Алтанширээ сум/ 142.2 сая төгрөг" гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

21.Төслийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын их засварын багцад “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар, /Дорноговь, Иххэт сум/, 347.9 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

22.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын зардалд “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх, 12 дугаар хороо/, 4,000.0 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

23.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлын багцад багтах Ахмад настны хөгжил хөтөлбөрт “233.5 сая төгрөг” нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

24.Төслийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын багцад “Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, 2,800.0 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Гарамжав,
Х.Нямбаатар, Д.Сумъяабазар
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

25.Монгол Улсын 2018 оны төсвийн жилээс эхлэн Боловсрол, соёл, шинжлэх хаан, спортын салбарын орон нутаг дахь харьяа байгууллагын байр ашиглалттай холбоотой зардлын 110.8 сая төгрөгийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт нь дэмжлэг хэлбэрээр шилжүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаа
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

26./Төсвийн байнгын хорооны дэмжээгүй 25-р саналыг гишүүдийн олонхи дэмжихгүй нөхцөлд хураалгана, дэмжсэн нөхцөлд хураалгахгүй/ Дээрхи санал дэмжигдсэнтэй холбоотойгоор зардлыг орон нутагт шилжүүлж байгаатай холбогдуулан

Боловсролын тухай болон Соёлын тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаа
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

27.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад “Шинжлэх ухааны академийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх/, 3,500.0 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

28.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын их засварын багцад “128 дугаар цэцэрлэгийн кабелийн засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, 23.9 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

29.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын их засварын багцад “Сургуулийн барилгын их засвар, Хөвсгөл, Ханх сум, 174.8 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

30.Төслийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын багцад “Сэргээн засах болон хөнгөвчлөх асаргаа, сувиллын төв, зураг төсөвтэй хамт 500.0 сая төгрөг” гэж шинээр нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

31.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр өөрийн орлогоос санхүүжих 48,000.0 сая төгрөг гэснийг 25,000.0 сая төгрөг гэж, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,114.0 сая төгрөг гэснийг 25,000.0 сая төгрөг гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан,
М.Оюунчимэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

32.Өмнөговь аймгийн Цогтцэций суманд цэцэрлэгийн зориулалтаар баригдсан иргэн Э.Эрдэнэбаатарын эзэмшлийн барилгыг төрд худалдан авахад шаардагдах 1,458.0 сая төгрөгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хөрөнгө оруулалтын зардалд шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболд
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

33.Төслийн хоёрдугаар хавсралтын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хөрөнгө оруулалтын багцад багтах 10 дугаар зүйлийн 10.2.1.3 дахь дэд заалтын “1,000.0 сая төгрөг” гэснийг “1,500.0 сая төгрөг” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулга
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

34.Төслийн хоёрдугаар хавсралтын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад “8 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, /Хэнтий, Хэрлэн сум/, 42.9 сая төгрөг гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулга
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

35.Төслийн хоёрдугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 28 дахь хэсгийн урсгал зардалд Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд зориулж Эрүүл мэндийн яамны урсгал зардалд 1,500.0 сая төгрөг” гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулга
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

36.Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын багцад “Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/, эхлэх хугацаа 2018, дуусах хугацаа 2019, төсөвт өртөг 2,600.0 сая төгрөг, 2018 онд санхүүжих 500.0 сая төгрөг” гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун,
Н.Номтойбаяр
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

37.Төслийн 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв зарцуулах эрхийн хүснэгтийн 25 дахь хэсэг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын урсгал зардалд Инноваци, өндөр технологийг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий 200.0 сая төгрөгийг 1,139.2 сая төгрөг болгон нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал

**/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

38. Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын багцад “Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом сум/, эхлэх хугацаа 2018, дуусах хугацаа 2019, төсөвт өртөг 5,019.7 сая төгрөг, 2018 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

39. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад “Сургуулийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/, 2,800.0 сая төгрөг” гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

40. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын боловсролын салбарын хөрөнгө оруулалтын багцад “Сургуулийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/, 10,500.0 сая төгрөг” гэж шинээр нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжсэн/**

41. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж уг зардлыг Биеийн тамир, спортын газрын урсгал зардалд хуваарилах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг
/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хороо дэмжээгүй/**

42. Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2018 оны төсвийн багцын нөхөн сонгуулийн зардлыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан
/Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй/**

43. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн урсгал зардалд 41 шүүгч, 62 шүүхийн захиргааны ажилтанд шаардагдах цалингийн зардлыг 1,820.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 218.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар
/Хууль зүйн байнгын хороо дэмжсэн/**

44. Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардалд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад 3,500.0 сая төгрөгийг нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Л.Мөнхбаатар
/Хууль зүйн байнгын хороо дэмжсэн/**

45.“Ажилсаг Монгол” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх, “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлэх судалгаа хийх, төсөл боловсруулах, Ази, Европын өндөр хөгжилтэй орнуудын туршлага судлах, туршилтаар залуучууд, мэргэжлийн ажилтнууд, жижиг, дунд үйлдвэрийн эзэд, мастеруудыг давтан сургах, хэлний сургалтад хамруулах зэрэг үйл ажиллагаанд 5,000.0 сая төгрөгийг нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва
/Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн/**

46.Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвийн шороон замыг хайрган хучилттай зам болгоход шаардагдах 250.0 сая төгрөгийг Зам тээврийн хөгжлийн сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар
/Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй/**

47.Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын төвийн айл өрх, албан байгууллагуудыг ундны цэвэр усаар хангах зорилгоор худаг гаргах, худгийн байгууламж, ус түгээх машин худалдан авахад зориулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын хөрөнгө оруулалтын зардлыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар
/Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй/**

48.Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын төвийг нэгдсэн халаалтын системд холбох ажилд 800.0 сая төгрөгийг Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар
/Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй/**

49.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2, 7 дугаар багуудын дундуур 2.7 км хатуу хучилттай авто зам барихад шаардлагатай 3,515.6 сая төгрөгийг Зам тээвэр, хөгжлийн сайдын багцын хөрөнгө оруулалтын зардалд нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт
/Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй/**

50.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2, 7 дугаар багийн үерийн хамгаалалтын сувгийн ажилд 2,401.0 сая төгрөгийг Барилга, хот байгуулалтын сайдын багцад нэмж тусгах.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт
/Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй/**

51.Хилийн цэргийн 0243 дугаар ангийн барилга, байгууламж /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ гэсэн төсөл арга хэмжээний 2018 онд санхүүжих дүнг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат,
Д.Оюунхорол, О.Батнасан, Н.Амарзаяа,
Н.Оюундарь, С.Бямбацогт**

52.Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “MNB word, MNB sport” сувгийн эфирийн өргөтгөл /Улаанбаатар/ төсөл арга хэмжээнд 1,800.0 сая төгрөг тусгах

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат,
Д.Оюунхорол, Ш.Раднаасэд, Л.Оюун-Эрдэнэ**

53. Зам тээврийн сайдын багцын XIV.1.2.4-т тусгагдсан “Хорооллын доторхи авто замын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 2а, 3а байр/ төсөл, арга хэмжээг “Хорооллын доторхи автозамын засвар /Улаанбаатар, Баянгол, 1, 2, 3, 4-р хорооны байруудын доторхи холбосон зам, 03, 60, 33, 34, 7-3-р байр, 49, 72, 64, 65, 66, 76 дугаар байр, 2а, 3а, 52-р байр/ гэж өөрчлөх

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ

54. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг 4.0 тэрбум төгрөгөөр бууруулах

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар
Цөөнх: Ч.Хүрэлбаатар**

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

2018 ОНД САНХҮҮЖИХ ДҮНГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		2018 оны өргөн барьсан төсөл		Гүйцэтгэл	Зөрүү
			Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	НИЙТ	
1	XIII.1.1.12	Сургуулийн барилга, 640 суудал /Булган, Булган сум, 1 дүгээр сургууль/	2012	2018	4,300.0	1,268.1	3267.6	(235.70)
2	XIII.2.1.7	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2018	3,406.2	437.4	2995.8	(27.00)
3	XIII.2.1.10	Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Уянга сум/	2010	2018	1,402.0	190.6	1244.2	(32.80)
4	XIII.2.1.11	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2018	8,353.7	306.0	8352.4	(304.70)
5	XIII.3.1.2	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2018	8,229.3	1,985.1	6390.2	(146.01)
6	XIII.3.1.3	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2018	6,378.0	1,731.5	4827.7	(181.20)
		ДҮН			32,069.2	5,918.7	27,077.9	(927.4)

НЭМЖ ТУСГАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	/сая төгрөг/ Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	МОНЦАМЭ агентлагийн хэвлэлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2018	2018	300.0	300.0
2	Аврах гал унтраах ангийн барилга /Ховд, Зэрэг сум/	2018	2018	450.0	450.0
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Говь-Алтай, Эрдэнэ сум/	2018	2019	1,000.0	500.0
4	Багийн төвийн жишиг барилга /Төв, Батсүмбэр сум, Үдлэг баг/	2018	2018	180.0	180.0
5	Төрийн ордны барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2018	2018	1,000.0	1,000.0
6	Монгол дахь Кубын элчин сайдын яамны байрын их засвар /Улаанбаатар/	2018	2018	350.0	350.0
7	MNB WORLD, MNB Sport сувгийн эфировийн өргөтгөл /Улаанбаатар/	2018	2018	1,200.0	1,200.0
8	Улсын бүртгэлийн хэлтсийн барилга /Төв, Зуунмод сум/	2018	2019	690.0	400.0
9	Ахмадын өргөөний тоног төхөөрөмж /Сүхбаатар, Мөнххаан сум/	2018	2018	30.0	30.0
10	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2019	5,844.1	600.0
11	Нэгдсэн халаалтын зуухны тогооны их засвар /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2018	2018	153.0	153.0
12	Шинэ хороо төсөл /Улаанбаатар/	2018	2018	2,000.0	2,000.0
13	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/	2018	2019	626.5	500.0
14	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Дорноговь, Иххэт сум/	2018	2019	1,600.0	300.0
15	Сургуулийн барилга, 320 суудал /Дундговь, Дэлгэрхангай сум/	2018	2019	2,377.0	500.0
16	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Чандмань сум/	2018	2018	900.0	900.0
17	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Уулбаян сум/	2018	2019	900.0	200.0
18	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Эрдэнэ сум/	2018	2018	900.0	900.0
19	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2018	2019	2,160.0	250.0
20	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Халиун сум/	2018	2019	900.0	500.0
21	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Дөрвөлжин сум/	2018	2019	1,000.0	500.0
22	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2018	2019	1,000.0	500.0
23	Цэцэрлэгийн барилга, 175 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо/	2018	2019	1,500.0	1,000.0
24	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Түвшинширээ сум/	2018	2019	2,160.0	200.0
25	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Цогт сум/	2018	2019	900.0	500.0
26	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан, Жаргалант тосгон, 116 дугаар цэцэрлэг/	2018	2018	500.0	500.0
27	Соёлын төвийн барилгын дуусгал /Өмнөговь, Номгон сум/	2012	2018	519.0	519.0
28	Соёл, спортын цогцолборын барилга /Дорноговь, Дэлгэрэх сум/	2018	2018	1,200.0	1,200.0
29	Соёлын төвийн барилгын их засвар /Дорноговь, Алтанширээ сум/	2018	2019	142.2	100.0
30	Соёлын төвийн барилгын их засвар /Өмнөговь, Цогтцэций сум/	2018	2018	300.0	300.0
31	Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2018	2018	100.0	100.0
32	Соёлын төвийн барилгын их засвар /Сүхбаатар, Асгат сум/	2018	2019	350.0	250.0
33	Спорт заалын барилга /Хэнтий, Баянхутаг сум/	2018	2019	750.0	400.0
34	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2018	2020	4,000.0	500.0
35	Онгийн голын модон гүүр /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум/	2018	2018	120.0	120.0
36	Толгойт-Орбит чиглэлийн авто замын уулвараас Орбит-Баянголын уулзвар хүртэлх авто замын их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2018	500.0	500.0
37	Авто вокзалын төвийн барилга /Төв, Зуунмод сум/	2018	2019	1,000.0	500.0
38	Шинэ хөдөө төсөл, жимс жимсгэнэ, малын үржил /Булган/	2018	2018	1,000.0	1,000.0
39	Инженерийн хийцтэй гүний худаг, 25 ш /Төв, Архуст, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцагаан, Зуунмод, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ сум/	2018	2018	600.0	600.0
40	Ногооны талбайн усжуулалтын системийн өргөтгөл, их засвар /Хөвсгөл, Тосонцэнгэл сум/	2018	2018	200.0	200.0
41	Эмнэлгийн барилгын их засвар /Сүхбаатар, Түмэнцогт сум/	2018	2019	221.7	100.0
42	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Тариалан сум/	2018	2019	1,800.0	500.0
43	Цэцэрлэгийн барилга /Ховд, Жаргалант сум/	2018	2019	2,105.7	500.0
44	Үндэсний ой санамж хөтөлбөр /Улаанбаатар/	2018	2018	1,000.0	1,000.0
45	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэмандал сум/	2018	2019	1,400.0	850.0
46	Сургууль, цэцэрлэгийн уурын зуухны засвар /Архангай, Эрдэнэмандал сум/	2018	2018	150.0	150.0
47	Ажилсаг Монгол хөтөлбөр /Улсын хэмжээнд/	2018	2018	1,000.0	1,000.0
	НИИТ			49,079.2	24,802.0

2018 ОНД САНХҮҮЖИХ ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		/сая төгрөг/ 2018 онд санхүүжилтийг нэмэгдүүлэх дүн
			Эхлэх	Дуусах	
1	VI.1.8	Соёл, спорт, амралт, аялал жуулчлалын цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/	2018	2019	500.0
2	VIII.1.4.1	Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/	2018	2018	6,000.0
3	X.2.1.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум/	2018	2019	250.0
4	X.3.1.6	Цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7, 9, 24, 25 дугаар хороо/	2018	2019	200.0
5	XII.1.27	Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/	2018	2020	250.0
6	XII.1.28	Үерийн хамгаалалтын барилга байгууламж, 1.8 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21, 27 дугаар хороо/	2018	2019	500.0
7	XIII.1.1.74	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо/	2018	2019	500.0
8	XIII.1.1.80	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	2018	2019	250.0
9	XIII.1.1.81	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо/	2018	2019	500.0
10	XIII.1.1.82	Сургуулийн барилга, 120 суудал /Өвөрхангай, Уянга сум, Жаргалант баг/	2018	2018	500.0
11	XIII.1.1.90	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо/	2018	2019	500.0
12	XIII.1.1.102	Дотуур байрын барилга худалдан авах /Өмнөговь, Гурвантэс сум/	2018	2019	500.0
13	XIII.1.1.108	Сургуулийн дотуур байр, урлаг, спортын заал, биеийн тамирын талбай /Ховд, Жаргалант сум, 7 дугаар сургууль/	2018	2019	100.0
14	XIII.1.1.110	Сургуулийн спорт заалын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Ганзам сургууль/	2018	2019	500.0
15	XIII.1.1.148	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/	2018	2018	500.0
16	XIII.1.1.152	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр баг/	2018	2019	250.0
17	XIII.1.1.154	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/	2018	2019	250.0
18	XIII.1.1.160	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	2018	2019	500.0
19	XIII.1.1.170	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2018	2018	350.0
20	XIII.1.1.172	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/	2018	2019	250.0
21	XIII.1.1.176	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/	2018	2019	250.0
22	XIII.1.1.180	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 6 дугаар баг/	2018	2019	250.0
23	XIII.1.1.191	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум, 23 дугаар цэцэрлэг/	2018	2018	1,000.0
24	XIII.1.1.198	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо/	2018	2019	250.0
25	XIII.1.1.200	Цэцэрлэгийн барилга, 125 ор /Баян-Өлгий, Сагсай сум/	2018	2018	489.0
26	XIII.1.1.204	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	2018	2019	200.0
27	XIII.1.2.15	Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2019	300.0
28	XIII.1.2.26	Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Алтанбулаг, Жавхлант сум/	2018	2019	150.0
29	XIII.2.1.5	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2019	1,000.0
30	XIII.2.1.20	Соёл, спортын цогцолборын барилга /Сэлэнгэ, Ерөө сум, Бугант тосгон/	2018	2018	300.0
31	XIII.2.1.23	Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Өлзийт сум/	2018	2019	500.0
32	XIII.2.1.30	Соёлын төвийн барилга, 250 суудал /Увс, Зүүнговь сум/	2018	2019	500.0
33	XIII.2.1.36	Соёлын төвийн барилга, 200 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	2018	2018	100.0
34	XIII.3.1.5	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	2010	2020	500.0
35	XIV.1.1.17	Сумын төвийг Мянганы замтай холбох хатуу хүчилттай авто зам /Дорнод, Баянтүмэн сум/	2018	2019	250.0
36	XIV.1.1.19	Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын нүхэн гарц /Дархан-Уул, Дархан сум/	2018	2019	500.0
37	XIV.1.1.22	Сумын төвийн доторх хатуу хүчилттай авто зам, 1.7 км /Архангай, Ихтамир сум/	2018	2019	500.0
38	XIV.1.1.24	Халуун усны байрнаас Их наран, Их нарангаас Буяны зам хүртэлх хатуу хүчилттай авто зам, 1.2 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2019	250.0
39	XIV.1.1.25	Баянбулагийн 2 дугаар гудамжнаас Мандал овооны 3 дугаар гудамж хүртэлх хатуу хүчилттай авто зам, 1.5 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2019	250.0
40	XIV.1.1.28	Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум/	2018	2019	11.0
41	XIV.1.1.34	Бооржийн голын төмөр бетон гүүр /Ховд, Мөст сум/	2018	2019	100.0
42	XIV.1.1.36	Мандалын голын төмөр бетон гүүр, 62 у/м /Баянхонгор, Галуут сум/	2018	2018	100.0
43	XVI.1.19	Хүнсний ногооны зоорь /Ховд, Жаргалант сум/	2018	2019	100.0
44	XVII.1.11	Шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 250кВт АТП /Сэлэнгэ, Мандал сум/	2018	2019	200.0
45	XVIII.1.11	Бельгийн Вант Улсын хөнгөлөлттэй эзэлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах төслийн монголын талын хөрөнгө /Ховд, Жаргалант сум/	2013	2019	2,000.0
46	XVIII.1.27	Эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Чандмань сум/	2018	2019	200.0
47	XVIII.1.33	Хүүхдийн эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2018	2019	300.0
48	XVIII.1.34	Эрүүл мэндийн төвийн барилга, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9, 10, 14, 16 дугаар хороо/	2018	2019	500.0
49	XVIII.3.9	Дүүргийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2018	2018	300.0
		НИИТ			24,500.0

**ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2018 ОНД
САНХҮҮЖИХ ДҮНГ БУУРУУЛСАН ДҮНГЭЭР
САНХҮҮЖИГДЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Эхлэх	Дуусах	Төсөв	2018 онд санхүүжих
1	Халдварт, сүрьеэгийн эмнэлгийн барилга, 30 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	2018	2019	2,037.6	500.0
2	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Шинэ- Идэр сум/	2018	2019	1,440.0	500.0
3	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Хөвсгөл, Галт сум/	2018	2018	450.0	450.0
4	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2018	2020	5,019.7	500.0
5	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Ховд, Жаргалант сум/	2018	2020	5,019.7	500.0
6	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2018	2020	8,500.0	500.0
7	Зооноз өвчин судлалын үндэсний төвийн агуулахын байрын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2018	350.0	350.0
	Нийт дүн			22,817.0	3,300.0